# Төв аймгийн Баян сумын нутагт орших “Шохойцагаан булаг” ХХК-ний “Шанд худаг” гантиг чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

2024 он

## ГАРЧИГ


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 4

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл ........ 4

1.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 7

1.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ........ 11

2024 уурхайн тэлэлт хийгдэх тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй. ........ 11

1.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт ........ 11

1.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт ........ 11

1.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 11

1.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 12

1.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 13

1.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ........ 15

1.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ........ 21

1.11 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ........ 22

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газар эзэмших гэрчилгээ ....4
Хүснэгт 2. MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүд....4
Хүснэгт 3. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай, Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай 2.0 га газрын булангийн цэгүүдийн солбицол ....5
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ....7
Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ ....11
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө....12
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....13
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ....15
Хүснэгт 9.Хэмжилт хийсэн үзүүлэлт....16
Хүснэгт 10. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн, мг/м$^3$....17
Хүснэгт 11. Усны шинжилгээний үзүүлэлтүүд ....17
Хүснэгт 12. Химийн шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0900:2018 стандарттай харьцуулсан байдал (Сорьц №1)....18
Хүснэгт 13. Судалгааны талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл ....19
Хүснэгт 14. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт ....19
Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүн....19
Хүснэгт 16. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж....20
Хүснэгт 17. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үзүүлэлтүүд ....20
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....21

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төсөл хэрэгжих газрын байршил....5
Зураг 2.Төслийн талбай орчмын сансрын зураг....6
Зураг 3.Засаг захиргааны хуваарь ....6
Зураг 4. Зүсэлт №1-ийн газарзүйн байрлал, хөрсний зүсэлт хийсэн цэг ....18

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| Төслийн нэр: | ▪ “Шанд худаг” гантиг чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл |
| Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр: | ▪ “Шохойцагаан булаг” ХХК<br>- Улсын бүртгэлийн дугаар: 2911001065<br>- Регистрийн дугаар: 2025833 |
| Төслийн товч танилцуулга, хүчин чадал | ▪ Жилд 50.0 мян.тн гантиг чулуу олборлох хүчин чадалтай |
| Төслийн зорилго: | ▪ Тус гантиг чулууны ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино. |
| Төслийн үргэлжлэх хугацаа | ▪ 40 жил |
| Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: | ▪ MV-017555 |
| Газар эзэмших гэрчилгээний дугаар: | ▪ №000018707, №000018706 |
| Нийт талбайн хэмжээ | ▪ 35.49 га |
| Имайл хаяг | ▪ nalgartushig@gmail.com |
| Утас | ▪ 976-99115636, 88116981 |

Төслийн байршил

MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн Шанд худаг нэртэй гантиг чулууны талбай нь Монгол орны төвийн хэсэгт, Төв аймгийн Баян сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 130 км, Багахангай дүүргээс урагш 21 км, Баян сумын төвөөс урд зүгт 6.5 км, төв автозамаас 1.5 км зайд байрлана.

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L48-36
- Талбайн хэмжээ: 35.49 га

Хүснэгт 1. Газар эзэмших гэрчилгээ

| Газрын гэрчилгээний дугаар | Газрын захирамж дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт | Хэмжээ |
|---|---|---|---|---|
| №000018707 | ЗД-ын А/58 2020.03.31 | 4107032068 | Уурхайн газар | 35.49 га |
| №000018706 | ЗД-ын А/152 2015.03.17 | 4107032068 | Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж | 2.0 га |
| **Нийт** | | | | **37.49** |

Хүснэгт 2. MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүд

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | градус | минут | Секунд | градус | минут | секунд |
| 1 | 107 | 35 | 43.47 | 47 | 12 | 40.71 |
| 2 | 107 | 35 | 43.45 | 47 | 12 | 23.73 |
| 3 | 107 | 36 | 23.46 | 47 | 12 | 23.73 |
| 4 | 107 | 36 | 23.46 | 47 | 12 | 11.72 |
| 5 | 107 | 35 | 41.46 | 47 | 12 | 11.72 |
| 6 | 107 | 35 | 41.46 | 47 | 12 | 41.72 |
| 7 | 107 | 35 | 49.47 | 47 | 12 | 41.73 |
| 8 | 107 | 35 | 49.47 | 47 | 12 | 40.73 |

Хүснэгт 3. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай, Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай 2.0 га газрын булангийн цэгүүдийн солбицол

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 107 | 35 | 31.11 | 47 | 12 | 17.33 |
| 2 | 107 | 35 | 29.58 | 47 | 12 | 21.97 |
| 3 | 107 | 35 | 35.99 | 47 | 12 | 22.96 |
| 4 | 107 | 35 | 37.28 | 47 | 12 | 18.17 |




Зураг 1.Төсөл хэрэгжих газрын байршил




Зураг 2.Төслийн талбай орчмын сансрын зураг




Зураг 3.Засаг захиргааны хуваарь

## 1.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| | | **АГААРЫН ЧАНАР** | |
| 1 | Ил уурхайгаас үүсэх тоосжилт<br><br>Хорт хийн ялгарал<br><br>Дуу чимээ шуугиан | Зам талбайг усалж байх | Хуурайшилт ихтэй өдрүүдэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихэссэн үедүүдэд уурхайн замын тоосжилтыг дарах усалгаар хийж ажилладаг. |
| 2 | | Хорт хийн хэмжээг багасгахын тулд машин механизмын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх | Уурхайд ашиглагдаж байгаа машин механизмын засвар үйлчилгээ тогтмол хийдэг. Мөн засвар үйлчилгээ тогтсон цэгт хийдэг.<br> |
| | | **ГАЗРЫН ГАДАРГА ХЭВЛИЙД** | |
| 3 | Газрыг үр ашиггүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах | Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах. | Тухайн жилд батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажлыг хийж гүйцэтгэдэг. /2024 оны АМГТГазраар баталгаажуулсан Уулын ажлын төлөвлөгөөг хавсралтаар хавсаргав./ |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт | |
|---|---|---|---|---|
| 4 | | Уурхайн орчныг тэмдэгжүүлэх, хил хязгаар тогтоох | Ачилт тээвэрлэлт гээд бүхий л замын холбогдолтой тэмдэг тэмдэглэгээг байршуулсан болно. |    |
| | | **ХӨРСӨН БҮРХЭВЧ** | | |
| 5 | Хөрсний бүтцэд гарсан өөрчлөлт<br><br>Хөрс хатуу, шингэн хог хаягдлаар бохирдох | Хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах | Хуулсан шимт хөрсийг шимт хөрсний овоолгод хураадаг болно. |   |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| | | | Шимт хөрсний овоолго харагдах байдал. |
| 6 | | Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх | Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон тохиолдолд тухай бүр цэвэрлэх, хөрс саармагжуулж ажилладаг. |
| 7 | | Ашиглахгүй болсон шороон замыг хаах, явахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ байршуулах | Ашиглагдахгүй байгаа замыг хааж, явахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.   |
| **ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС** | | | |
| 8 | Унд ахуйн ус бохирдох | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Гүний худгийн уснаас холбогдох аргачлалын дагуу дээж авч “Нарт ШУУН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. /Шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав./ |
| 9 | | Цэвэр ус нөөцлөх зориулалтын саванд хадгалах ба савны ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх | Ундны ус хадгалах болон зөөвөрлөх эрүүл ахуйн шаардлага хангасан ус хадгалах зориулалттай сав худалдан авч ашигладаг.  |
| 10 | Газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх | Газрын доорх усны хяналт шинжилгээ хийх | Гүний худгийн уснаас дээж авч лабораторид өгсөн. /Шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав./ |
| 11 | | Гүний худагт суурилуулсан тоолуурыг баталгаажуулах. | Гүний худагт тоолуур суурилуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. |
| 12 | Усны нөөцийн | Ус ашиглах дүгнэлт | Төв аймгийн БОГазартай ус ашиглуулах гэрээ байгуулан дүгнэлт гаргуулсан. Гэрээээ, дүгнэлтийг |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| | менежментийг сайжруулах | гаргуулах | хавсралтаар хавсаргав. |
| 13 | | Ус ашиглах зөвшөөрөл авах | Зөвшөөрлийг хавсралтаар хавсаргав. |
| 14 | | Хаягдал усны зөвшөөрөл авах | Зөвшөөрлийг хавсралтаар хавсаргав. |
| **УРГАМЛАН НӨМРӨГ** | | | |
| 15 | Уурхай, тээвэрлэлт, шорооны ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөх. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих | Уурхайн тосгоны ойролцоо 100ш улиасны суулгац тарьсан.   Мод тарьж байгаа байдал. |
| **АМЬТНЫ АЙМАГ** | | | |
| 16 | Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх | Орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох | Төв аймгийн Байгаль орчны газартай хамтран ажиллана. |
| 17 | | Уурхайн хашаанд үзлэг хийж бүрэн бүтэн байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд засаж сайжруулах (мал, амьтан унаж бэртэхээс сэргийлэх зорилгоор) | Уурхайн хашаанд тогтмол үзлэг хийж бүрэн бүтэн байдалд хянадаг, эвдрэл гэмтэл гарсан тухай бүрт нь засаж сайжруулдаг. |

### 1.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2024 уурхайн тэлэлт хийгдэх тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй.

### 1.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

| Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт |
|---|---|---|
| Уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх | Сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд тус сумын нутагт уурхайн эдэлбэр газар, орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх. | Төв аймгийн Байгаль орчны газартай хамтран ажиллана. |

### 1.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

### 1.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Түүх соёлын өв илрээгүй болно. Илэрсэн тохиолдол харьяаллын байгууллагад мэдээллэх шаардлагатай бүхий л арга хэмжээг хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх хэрэгтэй.

## 1.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | |
|---|---|---|
| | Байгалийн аюул гамшиг | |
| Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах | Компанийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Баян суман дахь Онцгой байдлын хэлтсийн даргаар, Гал унтраах шуурхай төлөвлөгөө, Галын аюулгүй байдлыг хангах дотоод журам”-ыг компанийн захирлаар баталгаажуулан ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. |
| | Галын аюул | |
| Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагаар хангаагүйгээс галын аюул гарах | Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах; | Галын дохиололын систем болон аюулгүй гарцын фосфортой тэмдэг тэмдэглэгээ, гал унтраах хэрэглэлийг болон бүх цех хэсгүүдэд галын сарааны иж бүрдлийг бүрэн суурилуулж ажилчдад танилцуулан сургалтаар тогтмол мэдээлэл өгдөг.   |
| | Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих (www.achhold¬ing.mn) | Үерээс хамгаалах үерийн далан шуудууг уурхайг тойруулан байгуулсан. |
| | Галын зоонуудад үзлэг хийж шаардлагатай бол сайжруулах арга хэмжээ авах | Галын аюулаас сэргийлж эрсдэлийг бууруулахын тулд ажлын байр болон ажилчдын амралтын байранд үзлэг шалгалт хийдэг. Галын аюулаас хамгаалах, зөөврийн гал унтраагуур болон ааварын шүршүүр зэргийг сар бүр үзэж шалгаж байгаа ба цахилгааны инженерийн хамт 7 хоног бүр шалгадаг. |
| | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар | |
| Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх | Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах | Аюулгүй ажиллагааны хурлыг тогтмол зохион байгуулж аюулгүй ажиллагаа, байгаль орчны бохирдол сэргийлэх арга хэмжээг танилцуулж байдаг. Сургалтыг 7 хоног тутам 1 удаа зохион байгуулдаг. |
| | Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах | Жил бүр Онцгой байдлын газраар “Галын шуурхай төлөвлөгөө”, “Гамшгийн шуурхай төлөвлөгөө” зэргийг батлуулж нийт ажилчдад танилцуулдаг. |
| | Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх | Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах сургалтанд хамруулж, семинар зохион байгуулсан. |

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | | |
|---|---|---|---|
| | Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах | Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авч эмийн сан |  |
| | Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах | Нийт ажилчидад хөдөлмөр хамгаалалтын хувцас хэрэгслээр хангаж ажилладаг, | |

## 1.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|
| **Ахуйн** хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах | Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих | Уурхайн ажилчдын амрах байр, ресторан зэрэгт хог хаягдлын ангилан хаях талаар зурагт самбаруудыг байршуулсан. |
| | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх | Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан хадгалах савыг байршуулан хаягжуулсан. Ахуйн хэрэглээнээс үүсч буй хог хаягдлыг ангилан хаях заавар, зөвлөмж, зурагт хуудсуудыг ажилчдын орон сууц, хоолны газарт нүдэнд ил харагдахуйц газар байршуулсан. |
| | Энгийн хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. | Хог хаягдлын мэдээ тайланг тогтмол гаргаж, бүртгэл явуулдаг. |
| Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт | Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах | Уурхайн тосгоны ойролцоо хог хаягдал хадгалах түр цэг байгуулж, талбайг цементлэн, ахуйн хог хаягдал хадгалах сав, аюултай хог хаягдал хадгалах сав тус тус байршуулсан. |
| | Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин | Төмөр хуванцар болон шил лааз бусад хог хаягдлыг ангилан ялгаж хийдэг савтай бөгөөд орон нутагтай хог хаягдлын гэрээний дагуу ажилладаг |

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|
| өвчин тархах | боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах | |
| | Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах | Хөрс бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах арга хэмжээг авч ажиллана. |
| | Хаягдал бохир усыг “Хийрэв” ХХК-ийн худалдаалж буй “Ариусан” бэлдмэлээр тогтмол ариутгаж бие засах газар луу зайлуулах | Ажилчдын ариун цэврийн өрөөг 7 хоногт 1 удаа Тамар био ариутгагч болон Ариусан бэлдмэлээр халдваргүйжүүлэлтийг хийдэг. Мөн хог хаягдлын цэг /Хогны цэг/ орчмыг ариутгадаг болно. |
| **Аюултай** хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй | Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах | Хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан хадгалах савыг байршуулан хаягжуулсан. |
| | Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан зайлуулах | Ажилласан тос тосолгоо хуримтлуулах сав байршуулсан бөгөөд одоогийн байдлаар хаягдал тос тосолгоо үүсээгүй байгаа болно.  |

## 1.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн бөгөөд хээрийн судалгааны үр дүнг тайланд хавсаргав.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|
| Агаарын чанар | | |
| Агаарын чанарын хяналт, Тоос нийт -PM10, PM2.5, CO, $NO_2$, $SO_2$ агууламж | Карьерын орчим-1цэг<br>Гадаад зам-1цэг<br>Уурхайн тосгон-1цэг | Уурхай орчмын агаарын PM 2.5 болон PM 10 тоосонцрын хэмжиж үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016-тай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна. Нийт 3 цэгээс хэмжилт хийсэн. |
| Хөрс | | |
| Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд, ph, чийг, ялзмаг, $P_2O_5$ | Шимт хөрсний овоолго-1 цэг<br>Карьер-1 цэг | Төслийн талбайд нийт 4 цэгээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн 2 дээжийг 300-500 гр, хүнд металлын 2 дээжийг 200-300 гр хэмжээтэй авсан. Хөрсний агрохимийн болон хүнд металл шинжилгээг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсралтаар хавсаргав./ |
| Хөрсний хүнд металлууд (Pb, As, CN, Hg гэх мэт) | Карьер-1 цэг<br>Засварын төв-1 цэг<br>Эвдэрсэн талбайгаас-1 цэг | |
| Хөрсний микробиологийн шинжилгээ | Тосгон-1 цэг<br>Нүхэн жорлонгийн орчим-1 цэг | |
| Усны чанар | | |
| Усны ерөнхий химийн шинжилгээ. | Ундны усны эх үүсвэр /гүний худаг/ | Унд ахуйн уснаас холбогдох аргачлалын дагуу дээж авч усны ерөнхий шинжилгээг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсралтаар хавсаргав./ |
| Хүнд металл тодорхойлох Pb, As, CN, Hg | Ундны усны эх үүсвэр /гүний худаг/ | |
| Микробиологийн шинжилгээ /5үзүүлэлт/ | Ундны усны эх үүсвэр /гүний худаг/ | |

## 1. Судалгааны талбайн агаарын чанар

***Судалгааны байршил, хамрагдсан цэг***

Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэрт байрлах “Шохойцагаан булаг” ХХК-ний “Шанд худаг” гантиг чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн талбай орчмын орчны агаарын бохирдлын дэвсгэр (фон) хэмжээг тодорхойлох нэг удаагийн хэмжилтийг хийв.

Тус уурхай орчимд хяналт шинжилгээний цэгүүдийг сонгохдоо салхины зонхилох чиглэл болон нөлөөллийн түвшнийг чухалчилж үзсэн бөгөөд тухайн хээрийн судалгааны үед үйл ажиллагаа явагдаагүй байсан. Нийт уурхайн зам, карьер, кемп гэсэн 3 цэгийг сонгон авч хэмжилт хийв.

**Хэмжилт, үнэлгээний арга зүй:** Үнэлгээний мэдээлэл цуглуулахад ажиглалтын болон хэмжилтийн аргуудыг ашиглан ажлын талбайн хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлтүүдийг тодорхойлов. Үүнд:

**Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис):** Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу DustTrak 8530 багажийн тусламжтай тодорхойлсон.

**Дуу чимээ:** Шуугианы хэмжилтийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу HAZ-SCANNER model HIM-6000 маркийн зөөврийн багажаар дуу шуугианы хэмжилт хийлээ.

**Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл**: Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.

- **Хүхэрлэг хий**: Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимжлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов.
- **Азотын давхар исэл**: Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфаналины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.

Хүснэгт 9.Хэмжилт хийсэн үзүүлэлт

| № | Шинжилгээ | Бохирдуулагч үзүүлэлт | Хэмжилт хийх багаж, төхөөрөмж | Хэмжилт хийсэн багаж, төхөөрөмжийн зураг |
|---|---|---|---|---|
| 1 | Орчны агаарын шинжилгээ | Орчны агаарт тоосны хэмжээ TSP | DustTrak 8530 |  |
| | | Хүхэрлэг хий | | |
| | | Азотын давхар исэл | | |

***<u>Хяналт шинжилгээний үр дүн</u>***

Хэмжилт, судалгааны материалыг SPSS-21 программыг ашиглан мэдээллийн бааз үүсгэж, холбогдох статистик боловсруулалт, шинжилгээг Цаг уур, орчны шинжилгээний газар, БО хэмжил зүйн итгэмжлэгдсэн төв лабораторид шинжүүлж үр дүнг тусгав.

Хүснэгт 10. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн, мг/м$^3$

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | $SO_2$ /Хүхэрлэг хий / | $NO_2$ /Азотын давхар исэл / | TSP Нийт тоос | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мг/м$^3$ | | | ДБа |
| 1 | Уурхайн зам | 2024.08.11 | 0.014 | 0.061 | 0.080 | 48 |
| 2 | Карьер | 2024.08.11 | 0.015 | 0.054 | 0.096 | 64 |
| 3 | Кемп | 2024.08.11 | 0.018 | 0.064 | 0.249 | 42 |
| **MNS 4585:2016 Хүлцэх агууламж /20 минут хэмжилт/** | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

**ДҮГНЭЛТ:**

Агаарын чанарын хяналтын нийт 3 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна. ТӨслийн талбай орчмын дуу чимээний түвшин нь ерөнхийдөө хэвийн бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээний хязгаарт байна.

## 2. Судалгааны талбайн газрын доорх усны чанар

Төслийн талбайд гүний худаг гаргасан бөгөөд энэхүү худгийн уснаас авсан дээжийг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Хүснэгт 11. Усны шинжилгээний үзүүлэлтүүд

| Анион | 1 дм$^3$-д байгаа | | | Катион | 1 дм$^3$-д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг/л | мг-экв/л | мг/ экв/% | | мг/л | мг-экв/л | мг/ экв/% |
| **Cl-** | 38.0 | 1.07 | 13.56 | **$Na^+$** | 6.00 | 0.26 | 3.30 |
| **$SO_4^{--}$** | 89.00 | 1.85 | 23.46 | **$K^+$** | 1.00 | 0.03 | 0.32 |
| **$NO_3^-$** | 20.00 | 0.32 | 4.08 | **$Ca^+$** | 108.0 | 5.39 | 68.24 |
| **$CO_3^-$** | 0.00 | 0.00 | 0.00 | **$Mg^+$** | 27.00 | 2.22 | 28.13 |
| **$HCO_3^-$** | 284.0 | 4.65 | 58.89 | **Fe** | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дүн** | **431.00** | **7.90** | **100.0** | **Дүн** | **142.00** | **7.90** | **100.0** |
| $HCO_3$-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 431 мг/дм$^3$<br>Анион катионуудын нийлбэр: 573 мг/дм$^3$<br>Ерөнхий хатуулаг: 7.61 мг-экв/дм$^3$<br>pH: 7.85<br>Хуурай үлдэгдэл, мг/л: 342 ppm<br>Цахилгаан дамжуулах чадвар: EC-0.846 ds/m<br>TDS:465 ppm | | | | | | Физик чанар:<br>Өнгө: 0-өнгөгүй<br>Үнэр: 0-үнэргүй<br>Булингар: тунгалаг | |

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

Хүснэгт 12. Химийн шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0900:2018 стандарттай харьцуулсан байдал (Сорьц №1)

| № | Химийн шинжилгээний үзүүлэлтүүд | Худгийн ус | MNS 0900: 2018 |
|---|---|---|---|
| 1 | Усан орчны (pH) | 7.85 | **6.5-8.5** |
| 2 | $Cl^{-}$, хлорид | 38.0 | **350.0** |
| 3 | $SO_4^{--}$ , сульфат | 89.0 | **500.0** |
| 4 | $NO_3^{-}$, нитрат | 20.0 | **50.0** |
| 5 | $Ca^{++}$, кальци | 108.0 | **100.0** |
| 6 | $Mg^{++}$, магни | 27.0 | **30.0** |

**ДҮГНЭЛТ:** “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн шинжилгээний хариу нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, III төрлийн цэнгэгдүү буюу харьцангүй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.Шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ (MNS 0900:2018) харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

## 3. Судалгааны талбайн хөрсний чанар

**Хээрийн судалгаа:** Хээрийн судалгаагаар судалгааны талбайтай танилцах, хөрсний төлөөлөл болохуйц цэгүүдэд зүсэлт тавих, GPS-ийн хэмжилт авах, морфологи бичиглэл хийх, хөрсний дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэсэн.

Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн төлөв байдлыг тодорхойлох хээрийн судалгааг 2024 оны 08-р сарын 11-ны өдөр хийж гүйцэтгэв. Нийт 5 цэгт хөрсний зүсэлт хийж, хөрсний агрохимийн 3 дээжийг 300-500 гр, хүнд металлын 3 дээжийг 300-500 гр, хөрсний эрүүл ахуйн 2 дээжийг 100гр хэмжээтэй тус тус авсан. Зүсэлт хийсэн цэгүүдийн газарзүйн байршлыг байршил тогтоогч GPS багажаар тэмдэглэсэн. Мөн хөрсний морфологи шинж чанарын бичиглэл хийсэн.

**Лабораторийн задлан шинжилгээ:** Хөрсний агрохими, хүнд металлын болон эрүүл ахуйн дээжийг “Нарт ШУУН Консалтинг” ХХК -ний Хөрс судлалын итгэмжлэгдсэн шинжилгээний лабораторид шинжлүүлсэн.

**Хөрсний морфологи болон хими физик шинж чанар.**

**Зүсэлт №1**




Зураг 4. Зүсэлт №1-ийн газарзүйн байрлал, хөрсний зүсэлт хийсэн цэг

Хүснэгт 13. Судалгааны талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

| Хөрсний морфологи бичиглэл | | |
|---|---|---|
| Байршил | | Төв аймгийн Баян сум |
| Координат | | 47°12'38.18"N |
| | | 107°35'42.34"E |
| Өндөр | | д.т.д 1416 метр |
| Газрын гадаргын налуу | | 6.1 (градус) |
| Ургамлын бүрхэвч | | 35-40% |
| Хөрсний нэр | | Уулын хар хүрэн хөрс |
| Гүн  | **А.** 0-10 10см | Цайвар хүрэн өнгөтэй, гадаргаасаа эхлээд сайр чулуутай, ургамлын үндэс багатай, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. |

Хүснэгт 14. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

| Зүсэлт № | Гүн, см | pH $H_2O$ | ЦДЧ dS/m | Ялзмаг % | Давс | $CaCO_2$ | $NO_3$ мг/100г | Солилцох суурь, мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| Зүсэлт 1 | 0-10 | 7.44 | 0.078 | 2.22 | 0.032 | 0.00 | 0.30 | 19 | 3 | 0.6 | 12 |
| | 10-40 | 8.28 | 0.066 | 2.41 | 0.027 | 0.00 | 0.25 | 16 | 7 | 0.8 | 4 |
| Дээж 1 | 0-20 | 8.28 | 0.103 | 2.05 | 0.042 | 1.60 | 0.40 | 12 | 6 | 1.6 | 6 |

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжийн ялзмагийн хэмжээ дунд зэрэг, ургамалд ашигтай хөдөлгөөнт фосфорын агууламж маш бага ба калийн агууламж бага хангамжтай байна. Солилцох суурь (Ca+Mg мг-экв/100 гр) 18-22 мг буюу дунд, хөрсний урвалын орчин дунд зэрэг шүлтлэг байна. Хөрсний хялбар уусах давсны агууламж (0.027-0.042) бага, 1.60%-ийн карбонаттай байна.

**Хөрсний механик бүрэлдэхүүн**

Хүснэгт 15. Хөрсний механик бүрэлдэхүүн

| Зүсэлт № | Гүн, см | Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Зүсэлт 1 | 0-10 | 11.4 | 57.0 | 13.2 | 8.4 | 2.1 | 7.9 | 18.4 |
| | 10-40 | 8.5 | 59.4 | 13.4 | 7.6 | 2.2 | 8.9 | 18.7 |
| Дээж 1 | 0-20 | 11.9 | 60.8 | 11.2 | 8.3 | 2.6 | 5.2 | 16.1 |

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

## Хөрсний бохирдол

### Хүнд металлын агууламж

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 3 дээж авч “Нарт ШУУН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д тус бүр Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 16. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

| Дээж авсан цэгийн дугаар | Дээж авсан гүн, см | Хүнд металлын агууламж мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ni /никель/ | Cd /кадмий/ | Pb /Хар тугалга/ | Zn /цайр/ | Cr /хром/ | Cu /зэс/ |
| Зүсэлт 1 | 0-10 | 8.8 | 0.0 | 20.0 | 68.1 | 48.7 | 8.9 |
| Дээж 2 | 0-10 | 12.3 | 0.0 | 16.7 | 45.4 | 55.6 | 17.5 |
| Дээж 3 | 0-10 | 9.6 | 0.0 | 14.2 | 76.7 | 66.7 | 6.2 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/ | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 1 | 50 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 1.5 | 70 | 150 | 100 | 80 |
| Шаварлаг хөрс | | 150 | 3 | 100 | 300 | 150 | 100 |

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үр дүнг MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад элсэрхэг хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс Дээж 3-аас Хром 6.7 мг-иар их гарсан байна.

### Хөрсний эрүүл ахуй

Хүснэгт 17. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үзүүлэлтүүд

| Дээжний дугаар | Нянгийн тоо MNS 6341:2012 | Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 5367:2004 | | Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012 | |
|---|---|---|---|---|---|
| | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| Дээж 4 | $5.9*10^5$ | ≥0.01 | 1 | ≥0.1 | 1 |
| Дээж 5 | $6.4*10^5$ | ≥0.01 | 1 | ≥0.1 | 1 |

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297:2019) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

**ДҮГНЭЛТ:** Тус талбайд уулын хар хүрэн хөрс тархсан. Тус хөрснөөс авсан химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжийн ялзмагийн хэмжээ дунд зэрэг, ургамалд ашигтай хөдөлгөөнт фосфорын агууламж маш бага ба калийн агууламж бага хангамжтай байна. Солилцох суурь (Ca+Mg мг-экв/100 гр) 18-22 мг буюу дунд, хөрсний урвалын орчин саармаг байна. Хөрсний хялбар уусах давсны агууламж (0.027-0.042) бага, 1.60%-ийн карбонаттай байна.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон хортой, аюултай агууламжаас бага байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297:2019) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

## 1.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|
| Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа). | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан хийлгэхээр тохиролцсон болно. |
| Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулсан. |
